



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 17/39

Арвайхээр сум

Нэмэлт гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.6, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 448 дугаар “Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн өөрчлөлтийг тооцож, магадлалын дүнгээр баталгаажсан үнийн зөрүүг гэрээнд тусгаж, хугацааг тодотгон нэмэлт, өөрчлөлт оруулан гэрээ байгуулах ажлуудыг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтад тусгагдсан төсөл, арга хэмжээний гэрээний үнийн дүн, хугацаанд өөрчлөлт оруулан гэрээ байгуулан, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т даалгасугай.

3. Нэмэлт ажлын санхүүжилтийг хуваарийн дагуу олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСА Г ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0092

Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 01-ны өдрийн 0119 дугаар захирамжийн хавсралт



УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВТ ӨРТГИЙН ӨӨРЧЛӨЛТИЙГ ТООЦОЖ МАГАДЛАЛЫН ДҮНГЭЭР БАТАЛГААЖСАН ҮНИЙН ЗӨРҮҮГ ГЭРЭЭНД ТУСГАЖ, ХУГАЦААГ ТОТОДГОН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАН АЖЛЫН ЖАГСААЛТ

№	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Гүйцэтгэгчийн нэр	Хуучин гэрээний дүн	Өөрчлөгдөх гэрээний дүн	2023 онд санхүүжих дүн
			Эхлэх	Дуусах				
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД								
1	XII.1.51	Сумын төвийн цэвэр усны шугам (Өвөрхангай, Төгрөг сум)	2021	2023	"Гуа орд" ХХК	1,444,479,234	2,000,000,000	1,292,500,000
2	XII.1.108	Гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээний холболт (Өвөрхангай, Арвайхээр сум)	2022	2023	"Мөнх-Урлал" ХХК "Бага-Хөгшин" ХХК түншлэлээр	1,500,000,000	2,800,000,000	1,300,000,000
		Дүн				2,944,479,234	4,800,000,000	2,592,500,000
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗАР								
3	X.1.1.94	Сургуулийн барилгын өргөтгөл, 240 суудал (Өвөрхангай, Арвайхээр сум)	2020	2023	"Сод-Ээл" ХХК	1,275,742,107	1,643,600,000	176,317,630
4	X.1.1.133	Цэцэрлэгийн барилга, 50 ор (Өвөрхангай, Хужирт сум)	2020	2023	"Баяндөхөмийн хурд" ХХК	410,967,508	527,044,039	77,100,000
5	X.1.1.207	Сургуулийн барилга, 440 суудал (Өвөрхангай, Бат-Өлзий сум)	2021	2023	"Бако констракшн" ХХК	4,822,705,070	7,852,656,921	2,852,656,921
6	X.1.1.199	Бага сургуулийн барилга 240 ор (Өвөрхангай Өлзийт сум)	2021	2023	"Тэд констракшн" ХХК	1,499,955,909	1,774,055,909	274,100,000
7	XIII.1.1.14	Дотуур байрны барилга, 100 ор (Өвөрхангай, Хархорин сум, 2 дугаар сургууль)	2021	2024	"Өндөр бөх" ХХК	1,000,000,000	2,377,200,000	100,000,000
8	XIII.1.1.114	Сургуулийн номын сан, урлаг заалны өргөтгөл (Өвөрхангай, Арвайхээр сум, 4 дүгээр сургууль)	2021	2024	"Гурван тахилгат-Оргил" ХХК	1,115,226,287	1,965,500,000	100,000,000

9	XIII.1.1.169	Цэцэрлэгийн барилга, 150 ор (Өвөрхангай, Арвайхээр сум)	2021	2024	"Энх баялаг констракшн" ХХК	1,248,000,000	2,371,000,000	100,000,000
10	X.1.1.347	Цэцэрлэгийн барилга, 150 ор (Өвөрхангай, Бат-Өлзий сум)	2021	2024	"Шилүүстэй хайрхан" ХХК	1,300,000,000	2,161,400,000	100,000,000
11	X.1.1.352	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, урлаг заал (Өвөрхангай, Хужирт сум)	2021	2024	"Сонор гуа солюшн" ХХК	249,930,198	441,700,000	100,000,000
		Дүн				12,922,527,079	21,114,156,869	3,880,174,551
СОЁЛЫН САЙД								
12	XI.1.8	Соёлын төвийн барилга, 240 суудал (Өвөрхангай, Баянгол сум)	2019	2023	"Тэрхийн-Ундраа" ХХК	1,023,500,000	1,513,600,000	490,100,000
13	XI.1.42	Музейн барилга (Өвөрхангай, Арвайхээр сум)	2020	2023	"Бага хөгшин" ХХК	5,880,000,000	6,830,600,000	941,500,000
		Дүн				6,903,500,000	8,344,200,000	1,431,600,000
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД								
14	XV.1.79	Зооноз өвчин судлалын төвийн барилга (Өвөрхангай, Арвайхээр сум)	2021	2024	"Оазисленд констракшн" ХХК	1,745,973,099	2,680,000,000	100,000,000
15	XV.1.81	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл (Өвөрхангай, Богд сум)	2021	2024	"Дуутын нуруу" ХХК	1,000,000,000	1,587,000,000	100,000,000
16	XV.1.82	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл (Өвөрхангай, Хужирт сум)	2021	2024	"Воком констракшн" ХХК	999,900,000.0	1,708,000,000	100,000,000
17	XV.1.86	Эрүүл мэндийн төвийн өргөтгөл (Өвөрхангай, Хайрхандулаан сум)	2022	2024	"Арвайншагшаа" ХХК	300,000,000	546,500,000	100,000,000
		Дүн				4,045,873,099	6,521,500,000	400,000,000
		Нийт дүн				26,816,379,412	40,779,856,869	8,304,274,551